

Хяналт шалгалт хийсэн  
тухай

***Хяналт шалгалтын зорилго***

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, Булган аймгийн Засаг даргын баталсан 2017 оны 04 сарын 10-ны өдрийн 1/06 дугаар удирдамжийн дагуу Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон бусад холбогдох дүрэм, журам, тушаалуудын хэрэгжилтийг хангуулж, үндсэн үйл ажиллагааны байдал, зохион байгуулалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны байдлыг шалгаж, ололт амжилтыг бататгаж, зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино.

***Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа***

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ж.Оюун  
2017 оны 04 сарын 17-ны өдрөөс хуанлын 6 хоног

***Шалгалтанд хамрагдсан байгууллагын нэр***

Рашаант сумын Ирээдүй цэцэрлэгийн 2015-2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаа хамрагдав.

***Шалгалтанд хамрагдсан асуудал***

- ✓ Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн гаргасан заавар, журам, дүрмийн хэрэгжилтийн байдал
- ✓ Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, тайлан тэнцэл гаргалт, орлого, зарлагын гүйлгээг үндсэн баримт, бараа материалын тайлан, нягтлан бодох бүртгэлийн журналууд, дансны бичилтүүдтэй тулган шалгах
- ✓ Гадаад, дотоод албан томилолтын зардлын тооцоо бодолтын байдал
- ✓ Орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, данс бүртгэлд тусгасан байдал
- ✓ Байгууллага хоорондын тооцоо өглөг авлага, түүний баталгаажуулалт, бүртгэл тайланд тусгасан байдал
- ✓ Ажиллагсдын цалин хөлс, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн дагуу тогтоож, бодож олгосон байдал
- ✓ Нягтлан бодогчийн хууль тогтоомжид заасан үүргийн биелэлт

- ✓ Өмнөх шалгалтаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, актын барагдуулалт
- ✓ Дотоод хяналт зохион байгуулсан байдал
- ✓ Шилэн дансны хуулийн хэрэгжилт

### ***Шалгалтанд хамрагдсан байгууллагын талаарх товч мэдээлэл***

Рашаант сумын хоёрдугаар багт байршилтай 9011951 регистрийн дугаартай “Ирээдүй” цэцэрлэг нь үндсэн 19 ажиллагсадтай ба үүнээс эрхлэгч 1, үндсэн багш 4, туслах багш 4, дуу хөгжмийн багш 1, тогооч 1, туслах тогооч 1, нярав 1, манаач 1, үйлчлэгч 1, галч 4, нүүдлийн гэр цэцэрлэгийн багш, туслах багш 2 гэсэн орон тоотойгоор сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг явуулсан байна.

Тус цэцэрлэгийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд 1-р гарын үсгийг 2015 оны 01 сарын 01-ээс 10 сарын 30-ны өдрийг дуустал И.Булгантамир, 2015 оны 11 сарын 01-ээс 2016 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал З.Цэцэнбилэг, 2-р гарын үсгийг 2015 оны 01 сарын 01-ээс 2016 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал С.Шинэбилэг нар зурсан ба сумын төрийн санд бүртгэлийн 041615201 тоот, нэмэлт санхүүжилтийн 041615401 тоот данстайгаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн ба нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох “CTS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

2015 оны 01 сарын 01-ээс 2016 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал няраваар П.Ганчимэг ажилласан байна.

### ***Өмнөх шалгалтын талаар***

Булган аймгийн Аудитын газраас тус цэцэрлэгийн 2016 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 185.0 мянган төгрөгийн шатахууныг орлогод аваагүй дутагдуулсаныг төлүүлэхээр акт тогтоосон ба барагдуулалтын хугацаа болоогүй байна.

### ***Шалгалтын явцад хийгдсэн ажил, шалгалтанд хамрагдсан асуудал***

Тус цэцэрлэгийн 2015-2016 оны касс харилцахын баримт, эрхлэгчийн тушаал, ажлын цаг ашиглалтын бүртгэл, цалингийн карт, хүнс, бараа материалын тайлан, агуулахын бүртгэл, багшийн ирцийн бүртгэл, санхүүгийн тайлан, хүнс бараа материал нийлүүлэх тендерийн баримт бичиг зэрэг баримт материалуудад тулгуурлан эрхлэгч З.Цэцэнбилэг, нягтлан бодогч С.Шинэбилэг, нярав П.Ганчимэг нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

### **Санхүүжилт, орлогын талаар:**

2015 онд улсын төсвөөс 238822.3 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж тодотголоор төсвийг 11204.7 мянган төгрөгөөр хасч, 227617.6 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

2016 онд улсын төсвөөс 269488.0 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж тодотголоор төсвийг 6000.0 мянган төгрөгөөр /түлш халаалт 4000.0

мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэл 2000.0 мянган төгрөг/ нэмж, 275488.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан.

#### **Төсөвт зардлын талаар:**

**2015 онд** төсөвт зардлыг 227617.6 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 216588.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 11029.3 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төлөвлөгдсөн зардлаас цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 7308.3 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 803.8 мянган төгрөг, хоол 2707.3 мянган төгрөг, тээвэр шатахуун 127.2 мянган төгрөг, түлш халаалт 82.7 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

Төсвийн нийт зардлын 57.9 хувь буюу 131828.8 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд, 6.4 хувь буюу 14501.1 мянган төгрөгийг ЭМНДШимтгэлийн зардалд, 11.6 хувь буюу 26514.2 мянган төгрөгийг тогтмол зардалд, 15.2 хувь буюу 34513.2 мянган төгрөгийг хоол хүнсний зардалд, 0.5 хувь буюу 1061.6 мянган төгрөгийг нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд, 0.8 хувь буюу 1858.5 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд, 0.8 хувь буюу 1718.6 мянган төгрөгийг хичээл сургалт үйлдвэрлэлийн дадлагын зардалд, 1.2 хувь буюу 2517.6 мянган төгрөгийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардалд, бусад 9 нэр төрлийн зардалд 0.9 хувь буюу 2074.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

**2016 онд** төсөвт зардлыг 275488.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 239652.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 35835.3 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Төлөвлөгдсөн зардлаас цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 22206.1 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл 2442.7 мянган төгрөг, хоол 11171.4 мянган төгрөг, шуудан холбоо 9.4 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага 5.7 мянган төгрөг хэмнэгдсэн байна.

Төсвийн нийт зардлын 58.8 хувь буюу 140858.3 мянган төгрөгийг цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд, 6.5 хувь буюу 15494.4 мянган төгрөгийг ЭМНДШимтгэлийн зардалд, 11.5 хувь буюу 27543.2 мянган төгрөгийг тогтмол зардалд, 12.6 хувь буюу 30078.6 мянган төгрөгийг хоол хүнсний зардалд, 1.1 хувь буюу 2558.6 мянган төгрөгийг нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд, 0.6 хувь буюу 1614.4 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд, 0.8 хувь буюу 1952.3 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд, 2.4 хувь буюу 5754.6 мянган төгрөгийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардалд, 5.2 хувь буюу 12449.7 мянган төгрөгийг тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардалд, бусад 8 нэр төрлийн зардалд 0.6 хувь буюу 1348.6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

#### **Тэтгэмжийн талаар:**

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан буюу 5 жил тутамд олгох тэтгэмжийг 2015 онд 1 туслах багшид 2517.6 мянган төгрөг, 2016 онд бүлгийн болон туслах 2 багшид 5754.6 мянган төгрөг олгосон байна.

Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 5-д заасан заалтыг үндэслэн ахлах тогооч Д.Даваад өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжид 12449.7 мянган төгрөг олгожээ.

2015 онд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 4 хүнд 1697.8 мянган төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмж 2 хүнд 3431.2 мянган төгрөг олгосон бол 2016 онд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 3 хүнд 253.7 мянган төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмж 3 хүнд 8095.2 мянган төгрөг олгосон байна.

**Хүүхэд өдрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар:**

Тус цэцэрлэг нь 2014-2015 он, 2015-2016 оны хичээлийн жилд бэлтгэл, ахлах, дунд, бага гэсэн 4 бүлэгт 19000 хүүхэд хамруулахаас 19431 хүүхэд өдөр дунджаар 26 хүүхэд, нүүдлийн гэр цэцэрлэг нь 6,7,8 сард холимог нэг бүлэгт 840 хүүхэд өдөр хамруулахаас 938 хүүхэд өдөр дунджаар 22 хүүхэд хамруулж нийт хоолны зардалд 34022.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2015-2016, 2016-2017 оны хичээлийн жилд бэлтгэл, ахлах, дунд, бага гэсэн 4 бүлэгт 18400 хүүхэд өдөр хамруулахаас 16572 хүүхэд өдөр дунджаар 23 хүүхэд, нүүдлийн гэр цэцэрлэг нь 3 сараас 7 сар хүртэл холимог нэг бүлэгт 1520 хүүхэд өдөр хамруулахаас 1514 хүүхэд өдөр дунджаар 20 хүүхэд хамруулж, хоолны зардалд нийт 29816.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Үр дүнгийн урамшуулал, үр чадвар, шагналт цалингийн талаар:**

**2015 онд** эрхлэгч И.Булгантамирт Булган аймгийн Засаг даргын 2015 оны Б/39, А/307, А/279, А/377 дугаар захирамжаар 1-3-р улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 35-45 хувиар тооцож 846.4 мянган төгрөг, эрхлэгч З.Цэцэнбилэгт аймгийн Засаг даргын 2015 оны 12 сарын 21-ний өдрийн А/424 дүгээр захирамжаар 4-р улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 30 хувиар тооцож 202.3 мянган төгрөг тус тус олгосон байна.

Эрхлэгч И.Булгантамирт тус сумын Засаг даргын 2015 оны 03 сарын 31-ний өдрийн 51 дүгээр захирамжаар сумын Засаг даргатай байгуулсан 2013 оны үр дүнгийн гэрээгээ “А” үнэлгээгээр биелүүлсэн гэж 0.5 сарын үндсэн цалингаар, мөн 2015 оны 11 сарын 25-ны өдрийн Б/138 дугаар сумын Засаг даргын захирамжаар үр дүнгийн гэрээг “А” үнэлгээгээр биелүүлсэн гэж 1 сарын үндсэн цалин олгохоор шийдвэрлэж нийт 964.1 мянган төгрөгөөр урамшуулсан байна.

**2016 онд** эрхлэгч З.Цэцэнбилэгт Булган аймгийн Засаг даргын А/142, А/307, А/451, А/545 дугаар захирамжаар 1-4-р улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 39-45 хувиар тооцож нийт 943.0 мянган төгрөг, Рашаант сумын Засаг даргын 2016 оны 09 сарын 08-ны өдрийн А/103 дугаар захирамжаар Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээг “А” үнэлгээгээр биелүүлсэн гэж 1 сарын үндсэн цалин буюу 674.2 мянган төгрөг бүгд 1617.2 мянган төгрөгийн урамшуулалт цалин олгосон байна.

**2015 онд** цэцэрлэгийн эрхлэгчийн А/03, А/14, Б/12, Б/27 дугаартай тушаалуудыг үндэслэн ажлын үр дүнгийн урамшуулал 1-р улиралд 18 хүнд 10-45 хувиар тооцож 3327.6 мянган төгрөг, 2-р улиралд 17 хүнд 15-45 хувиар тооцож

2156.9 мянган төгрөг, 3-р улиралд 16 хүнд 12-45 хувиар тооцож 1243.7 мянган төгрөг, 4-р улиралд 18 хүнд 15-45 хувиар тооцож 3467.8 мянган төгрөг нийт 10196.1 мянган төгрөг, **2016 онд** цэцэрлэгийн эрхлэгчийн А/07, Б/12, Б/27, Б/41 дугаартай тушаалуудыг үндэслэн ажлын үр дүнгийн урамшуулал 1-р улиралд 17 хүнд 40-45 хувиар тооцож 3392.9 мянган төгрөг, 2-р улиралд 16 хүнд 25-45 хувиар тооцож 2289.1 мянган төгрөг, 3-р улиралд 14 хүнд 15-45 хувиар тооцож 1168.9 мянган төгрөг, 4-р улиралд 18 хүнд 41-45 хувиар тооцож 3602.7 мянган төгрөг нийт 10453.6 мянган төгрөг олгосон байна.

Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар хамт олноо манлайлан идэвхи санаачлагатай сайн ажилласан, хариуцсан ажилдаа амжилт гаргасан гэж 2015 онд 9,10,11,12 саруудад 9 албан хаагчид үндсэн цалингаас 20-75 хувиар тооцож 2940.7 мянган төгрөг, 2016 онд 3,4,5,6,9,10,11,12 саруудад 10 албан хаагчид үндсэн цалингийн 20-45 хувиар тооцож 3859.9 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл болон шагналт цалин олгосон байна.

Эрхлэгчийн 2015 оны 11 сарын 22-ны өдрийн Б/22 дугаар тушаалаар Төсвийн тухай хуулийн 16.5.5, Сангийн сайдын 2006 оны 292 дугаар тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 22.2-д заасныг үндэслэж нягтлан бодогч С.Шинэбилэгт үндсэн цалингийн 50 хувиар тооцож 280.4 мянган төгрөгийн цалин олгосон бол 2016 оны 09 сарын 21-ний өдрийн Б/27 дугаартай тушаалаар Засгийн газрын 2008 оны 54-р тогтоол, БШУСайдын 2013 оны 293, 2014 оны А/112 дугаар тушаалыг үндэслэж нягтлан бодогч С.Шинэбилэгт ажлын үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 45 хувиар тооцож 252.3 мянган төгрөг олгосон байна.

Авлага, өглөгийн талаар:

Шалгагдсан онуудад авлагагүй. 2015 онд хоолны 20.0 мянган төгрөгийн өглөгтэй байсныг 2016 онд барагдуулж, өглөггүй тайлан баланс гарсан байна.

Үндсэн хөрөнгийн тайлангаар:

2015 оны эхний үлдэгдэл 662806.9 мянган төгрөгийн хөрөнгө дээр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2550.0 мянган төгрөгөөр хоёрдугаар хоолны плетик, 340.0 мянган төгрөгийн махны машин, ХААН банкнаас 180.0 мянган төгрөгийн тоглоомын тавиур, Мобинет байгууллагаас 450.0 мянган төгрөгийн суурин компьютер нийт 3520.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 12 сарын 30-ны өдрийн 40 дугаар тогтоолоор эдэлгээний хугацаа дуусч шаардлага хангахгүй болсон 13 нэр төрлийн 1372.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг актлан данс бүртгэлээс хасч, оны эцэст 664954.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2016 оны эхний үлдэгдэл 664954.5 мянган төгрөгийн хөрөнгөөс Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 11 сарын 23-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор эдэлгээний хугацаа дуусч шаардлага хангахгүй болсон 2 нэр төрлийн 1129.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг актлан данс бүртгэлээс хасч, оны эцэст 663824.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Бараа материалын тайлангаар:**

2015 оны эхний үлдэгдэл 35005.7 мянган төгрөг дээр 3961.3 мянган төгрөгийн аж ахуйн, 399.2 мянган төгрөгийн бичиг хэрэг, 20310.9 мянган төгрөгийн түлш, шатах тослох материал, 58.3 мянган төгрөгийн эм боох, 34821.2 мянган төгрөг хүнсний материал худалдан авч, БСШУЯамны хөрөнгө оруулалтаар 2655.9 мянган төгрөгөөр 40 нэр төрлийн 132 ш тоглоом үнэ төлбөргүйгээр өгч, 58327.2 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, Цэцэрлэгийн эрхлэгчийн 2015 оны 12 сарын 30-ны өдрийн А/23 дугаар тушаалаар цаашид ашиглах боломжгүй болсон 82 нэр төрлийн 415 ш 2564.2 мянган төгрөгийн материалын актлан данс бүртгэлээс хасч оны эцэст 36321.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй.

2016 оны эхний үлдэгдэл 36321.2 мянган төгрөг дээр 6046.3 мянган төгрөгийн аж ахуйн, 185.5 мянган төгрөгийн бичиг хэрэг, 21112.0 мянган төгрөгийн түлш, шатах тослох материал, 30336.1 мянган төгрөг хүнсний материал худалдан авч, 55266.4 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, Цэцэрлэгийн эрхлэгчийн 2016 оны 12 сарын 23-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар цаашид ашиглах боломжгүй болсон 10 нэр төрлийн 91 ш 1554.0 мянган төгрөгийн материалын актлан данс бүртгэлээс хасч оны эцэст 37180.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарчээ.

Баянтээг ХХК-тай гэрээ байгуулж, иргэн Ж.Батболд, Н.Цогт нар тээвэрлэн 2015 онд 15368.0 мянган төгрөгөөр 192.1 тн нүүрс, 2016 онд 19152.0 мянган төгрөгөөр 245.1 тн нүүрс буулгасан байна.

2016 онд 02 сард цахилгаан тасарсаны улмаас цэцэрлэгийн цэвэр усны шугам хөлдсөн. 120 м газрыг урхаж трубаг гэсгээх, цэвэр ус оруулах ажлуудыг хийхэд ажлын хөлсөнд 270.0 мянган төгрөг, шатахуунд 610.0 мянган төгрөгийг зарцуулж, мөн ажилласан галч нарт 140 цагийн хөлс олгосон байна.

**Хүнс, бараа материал нийлүүлэх гэрээний талаар:**

**2015 оны 09 сард** тус цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж байсан И.Булгантамир нь 2015.10.06-2016.02.01 хүртэл Холбообаянбүрд ХХК-тай хүнс бараа материал нийлүүлэх гэрээг, сумын 4-р багийн иргэн Ш.Жамбалдоржтай сүү, цагаан идээ нийлүүлэх гэрээг, 2014.10.01-2015.02.01 хүртэл Хайлаастын худаг хоршоотой мах нийлүүлэх гэрээг байгуулсан бол эрхлэгч З.Цэцэнбилэг нь 2015.11.02-2016.11.02 хүртэл Бумбат баян хангай ХХК-тай мах нийлүүлэх гэрээг байгуулсан байна.

2015 онд нийт 34821.2 мянган төгрөгийн хүнс, 24729.7 мянган төгрөгийн бараа материал худалдаж авсан. Үүнээс Холбообаянбүрд ХХК-иас 19698.3 мянган төгрөгийн хүнс, 1144.4 мянган төгрөгийн бараа материал, иргэн Ш.Жамбалдоржоос 802.2 мянган төгрөг, М.Галбаатараас 2444.9 мянган төгрөгийн цагаан идээ, Хайлаастын худаг хоршооноос 6118.8 мянган төгрөгийн мах, Бумбатбаян хангай ХХК-иас 4698.0 мянган төгрөгийн мах худалдан авсан байна.

Гэрээ байгуулалгүйгээр **Болд-Ундрах ХХК-иас** 1192.5 мянган төгрөгийн мах, сумын иргэн Уранчимэгээс 16000 төгрөгийн бээлий, сумын эмийн сангаас 85.0 мянган төгрөгийн жавилан, витамин, сумын иргэн Ганзулаас 365.5 мянган төгрөгийн засварын материал, УБ хотоос 122.1 мянган төгрөгөөр хөөсөн самбар, 90.0 мянган төгрөгөөр 3 ш 1-р хоолны тогооны тен, 2890.0 мянган төгрөгөөр 2-р хоолны плетик, 206.5 мянган төгрөгийн засварын материал худалдаж авсан.

**2016 онд** тус цэцэрлэг нь хүнс, бараа материал нийлүүлэх тендерийн урилгыг 10.21-ний өдөр сумын Бумбат баян хангай ХХК, Холбообаянбүрд ХХК, Хайлаастын худаг хоршоо, Булганхангай ХХК, Бумбат дэлгэрэх ХХК, сумын иргэн Алтанбагана, Ц.Болдсайхан, Мягмарсүрэн, Дуламсүрэн, Галбаатар нарын 10 байгууллага, иргэнд өгч, хүлээлгэн өгсөн бүртгэл хөтөлсөн байна.

Дээрх байгууллагаас Холбообаянбүрд ХХК, Хайлаастын худаг хоршоо, Дуламсүрэн, Галбаатар нараас үнийн саналын материалыг цэцэрлэгт ирүүлсэн байна.

Сургууль, цэцэрлэг, сумын Үнэлгээний хорооны гишүүд Сумын ЗДТГазар хүнс, бараа нийлүүлэх иргэн, ААНэгжийг шалгаруулах хурлыг 11.02-нд нээлттэй явуулж, хамгийн бага үнийн санал өгсөн Холбообаянбүрд ХХК-тай хүнс бараа материал, Хайлаастын худаг хоршоо, иргэн М.Галбаатар нартай сүү цагаан идээ, Бумбатбаян хангай ХХК-тай мах нийлүүлэх /Дуламсүрэн/, Бумбат баян хангай ХХК-тай мах нийлүүлэхээр шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгохыг цэцэрлэгийн эрхлэгчид зөвлөсний дагуу Сумын Засаг даргын 2016.12.05-ны өдрийн А/139 тоот захирамжаар дээрх байгууллага, иргэдтэй гэрээ байгуулсан байна.

2016 онд нийт 30336.1 мянган төгрөгийн хүнс, 57679.9 мянган төгрөгийн бараа материал худалдаж авсан. Гэрээний дагуу Холбообаянбүрд ХХК-иас 15875.8 мянган төгрөгийн хүнс, 4066.4 мянган төгрөгийн бараа материал, М.Галбаатараас 3111.0 мянган төгрөгийн, Хайлаастын худаг хоршооноос 896.0 мянган төгрөгийн сүү цагаан идээ, Бумбатбаян хангай ХХК-иас 5647.5 мянган төгрөгийн мах худалдан авсан байна.

**Тендер зарлагдаагүй байх үед буюу гэрээ байгуулалгүйгээр** иргэн Буянтогтохоос 168.2 мянган төгрөг, иргэн Сэрчмаа 226.3 мянган төгрөг, Дөлгөөнбүрд ХХК-иас 328.0 мянган төгрөгийн мах, Мини ХХК-иас 1175.0 мянган төгрөгийн мах, Болд-Ундрах ХХК-иас 946.0 мянган төгрөгийн мах, иргэн Бат-Очироос 380.0 мянган төгрөгийн мах, иргэн Эрдэнэсүрэнгээс 198.8 мянган төгрөгийн мах, Гэндэнсамбуугаас 660.0 мянган төгрөгийн мах, иргэн Байгальмаагаас 286.0 мянган төгрөгийн мах, сумын Баянгол дугуй засвараас 77.5 мянган төгрөгөөр сэлбэг, сумын Их булаг дугуй засвараас 41.6 мянган төгрөгөөр дугуй, сумын иргэн Ариунчимэгээс 80.0 мянган төгрөгөөр сантехникийн багаж, сумын Мал эмнэлгээс 4.0 мянган төгрөгөөр хлорын шохой, цэцэрлэгийн туслах багш Одмандахаас 110.0 мянган төгрөгөөр блок, цэцэрлэгийн манаач Цогтбаатараас 40.0 мянган төгрөгөөр принтерийн хор, УБ хотоос 466.0 мянган төгрөгөөр пинлятор, насосны сэлбэг, галч Борхүүгээс 50.0 мянган төгрөгөөр автомат пускатель, Булган аймгийн Баянгол наран ХХК-иас 2000.0 мянган төгрөгөөр ор хөнжлийн даавуу худалдаж авсан байна.

### **Шалгуулагчийн ололттой болон дэвшилттэй тал**

- ✓ Цалин олгох болон гарт хүснэгтэд ажилтан, албан хаагчдаар гарын үсэг зуруулж баталгаажуулан санхүүгийн баримтад хавсаргасан байна.
- ✓ Хүнс, бараа материалын үлдэгдлийн бүртгэлийг хөтлөхдөө баримтын дугаарыг тавиагүйг эс тооцвол сайн хөтөлсөн байна.
- ✓ Нярав нь хүүхэд өдрийн гүйцэтгэлийг бүлэг бүрээр сар бүр гаргасан.
- ✓ Хандив, тусламжаар ирсэн хөрөнгийг тухай бүрд данс бүртгэлд тусгасан.
- ✓ Санхүүгийн тайлан балансыг цаг хугацаанд нь гаргаж, аудитаар баталгаажуулсан байна.

### **Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, шалтгаан**

1. Нүүрс, шатахуунаас бусад бараа материалыг нэр төрлөөр нь гаргаагүй.
2. Хүүхдийн эцэг эхээс нэг хичээлийн жилд бэлтгүүлэх сургалтын хэрэглэгдэхүүн, ариун цэврийн хэрэгслийг авч жагсаалт хөтөлсөн ч материал хүлээлцсэн хүмүүсээр гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй, журналын нийт ирвэл зохих болон ирсэн хүүхэд өдрийн тоо, өвчтэй, чөлөөтэй, тасалсан хүүхдийн тоог бүртгэж дүгнэдэггүй, ирцийн бүртгэлийг засварласан.
3. Багш нар хүүхэд өдрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг тогтмол гаргаж хэвшээгүй.
4. Ур чадварын нэмэгдлийг байгууллагадаа боловсруулсан журам, улирал тутам ажил дүгнэсэн үзүүлэлтгүйгээр олгосон.
5. Ажлын цаг ашиглалтын бүртгэлийг хөтөлдөг ч цайны цагийг автоматаар бүртгэдэг.
6. Ажилчдад олгосон 3 тн нүүрсийг тайланд зарлага болгоогүй.

### **Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгсөн байдал**

Шалгалтаар санхүү, бүртгэлийн 3 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

Улсын байцаагчийн 3 актаар 2954.2 мянган төгрөгийн төлбөр тогтоов.

### **Дүгнэлт**

Шалгагдсан онуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагааны анхан шатны баримтын бүрдүүлэлт, хөтлөлт хангалттай байна.

Санхүүгийн баримт материалд байгууллага дотооддоо хяналт хийгдээгүйгээс нийтлэг зөрчлүүд илэрч байна.

### **Цаашид авах арга хэмжээний санал**

- Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийг уншиж судлаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх
- Дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх
- Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу албан ёсны баримтыг үндэслэн зарцуулж байх



➤ Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, давтан гаргахгүй байхаар тодорхой ажил зохион байгуулж, акт, албан шаардлагын биелэлтийг хангах

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.ОЮУН













Агаар газар тариалангийн үйлдвэрлэл 2015 оны 07 сарын 25-ийн өдөр Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанд агаар газар тариалангийн үйлдвэрлэл

Агаар газар тариалангийн үйлдвэрлэл, газар тариалангийн үйлдвэрлэл, газар тариалангийн үйлдвэрлэл “Өдөр өдөр газар тариалангийн үйлдвэрлэл”-ийн 16.1.2 хэсэгт өдөр өдөр газар тариалангийн үйлдвэрлэл

БИЧСЭН:	ХҮЛЭЭН АВСАН:
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН	ХИШИГ-ӨНДӨР СУМЫН
УЛСЫН БАЙЦААГЧ	ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ж.ОЮУН	Б.БААСАНСҮРЭН
	НЯ-БО Б.ГЭРЭЛМАА
	НЯРАВ
	П.ЧИМЭГСАЙХАН



